



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

ААГ-ын Тэргүүлэх аудитор
Г.Оюунгэрэл
Утас: 99909224

Аудитын менежер:
Г.Эрдэнэчимэг
Утас: 99016320

Ахлах аудитор:
Л.Энх-Амгалан
Утас: 96383478

Аудитор:
Л.Магсаржалам
Утас: 99039903

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Уг тайланг **YAГ-ын Веб**
сайт-аас үзнэ үү.
www.audit.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй
ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
холбоотой асуудлаар нэмж
газрын харьяа Хөвсгөл аймгийн
тодруулах, асууж, лавлах зүйл
аудитын газар

байвал 70384043 дугаарын утас,

Байршил: АЗБТГ-ын байр

А холцна уу?

Цахим хуудас:
(Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын
www.audit.mn
А байр 3 давхарт)

2015 оны 2 дугаар сар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сүм
Утас: 70-36 97-93, факс: (976) 70-38 97-93

2017. 4. 20 № 4/411
таныг -ны № -т.

Аудитын гэрчилгээ

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккрузал сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15-дугаар зүйлийн 15.2.1-д заасан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудит хийв.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нь тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ГОЮУНГЭРЭЛ



Товчилсон үгийн жагсаалт	3
Аудитын гэрчилгээ	4
Нэг. Ерөнхий зүйл	
1.1 Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....	4
1.2.Аудитын зорилт, хамарсан хүрээ.....	4
1.3. Аудитын арга зүй.....	5
1.4 Хөвсгөл аймгийн ТЭЗ-ийн 2015 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал.....	5-6
1.5. Санхүүгийн дотоод хяналт	6
1.6. Шилэн дансны мэдээлэл.....	6
1.7. Материаллаг байдлыг тодорхойлох.....	6
Хоёр. Санхүүгийн тайлангийн талаар.....	6-
2.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал.....	6-8
6.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар	6-8
6.2 Арилжааны банк дахь ТЭЗ-дын харилцах дансны талаар	8
6.3 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлийн талаар.....	8
2.2. Авлагын бүртгэл, тайлагнал	
2.2.1. Авлагын бүтцийн талаар.....	8-10
2.2.2 Авлагатай холбоотой гарсан зөрчлийн талаар.....	10
2.3. Бараа материалын бүртгэл, тайлагнал	10-11
2.3.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар	10-11
2.3.2 Үнэ төлбөргүй авсан болон акталсан бараа материал.....	11
2.3.3 Бараа материалтай холбоотой зөрчлийн талаар.....	11
2.4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	12-13
2.4.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар.....	12-13
2.4.2 Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл.....	13
2.4.3 Үнэ төлбөргүй авсан буюу акталсан үндсэн хөрөнгө.....	13
2.4.4 Шилжүүлэн авсан үндсэн хөрөнгө.....	13
2.4.5 Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлийн талаар.....	13
2.5. Өр төлбөрийн бүртгэл тайлагнал	
2.5.1 Өр төлбөрийн бүтцийн талаар	13-14
2.5.2 Өр төлбөртэй холбоотой гарсан зөрчлийн талаар.....	14
2.6. Орлого, санхүүжилтийн талаар	
2.6.1. Улсын төсвийн санхүүжилт	14
2.6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт.....	14-15
2.6.3 Өөрийн орлого.....	15
2.6.4 Татварын орлого.....	16
2.6.5 Орлоготой холбоотой гарсан зөрчлийн талаар.....	16
2.7. Зарлагын талаар	
2.7.1 Санхүүжилтийн зарцуулалт.....	16
2.7.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт.....	16
2.7.3 Тусгай зориулалттай шилжүүлгийн зарцуулалт.....	17-19
2.7.4 Тусгай сангийн зарцуулалт.....	19-21
2.7.5 Зардалтай холбоотой гарсан зөрчлийн талаар.....	21
2.8. Эзэмшигчдийн өмчийн талаар	
2.8.1 Засгийн газрын хувь оролцоо.....	21
2.8.2 Хуримтлагдсан үр дүнгийн талаар.....	21
2.8.3 Дахин үнэлгээний нөөцийн талаар.....	22
2.9. Хөрөнгө оруулалтын талаар.....	22
Гурав. Орон нутгийн болон ТЗШ байгууллагуудын аудитын дүнгийн талаар.....	22-
3.1.ТЗШ-ийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	22
3.1.1 Эрүүл мэндийн байгууллагууд.....	22
3.1.2 Боловсролын байгууллагууд.....	22-23
Дөрөв. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын талаар	23
Тав. ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	23
Зургаа. Орон нутгийн сан, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлангийн талаар.....	23-24
Долоо. ОНӨҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитын талаар.....	24
Найм .ТЭЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитын талаар.....	24-25
Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	25
Арав. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар.....	25-26
Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	26-28
Арван хоёр. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	28
Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	28-29
Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	29
Арван тав. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	29
Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	29
Аудитын гэрчилгээний тохирох дүгнэлт.....	29
Менеджментийн захидал.....	30-35

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
ҮАГ	Үндэсний аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ОНӨААҮГ	Орон нутгийн өмчит аж ауйн үйлдвэрийн газар
САГ	Санхүүгийн аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
АЗД	аймгийн Засаг дарга
БОАЖГ	Байгал орчих, аялал жуулчлалын газар
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЕО	Ерөнхий орлого
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
НХХС	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ТЗШ	Төсвийн тусгай зориулалтын шилжүүлэг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ХТҮТ	Хот тохижилт үйлчилгээний төв
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
БХС	Байгал хамгаалах сан
ОНО	Орон нутгийн орлого

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Төсвийн тухай хуулийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийг дагуу Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйл, МУ-ын Ерөнхий аудиторын 2016 оны А/72 тушаалыг үндэслэн **Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн** 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд **ХӨА-/2017/01-СТА-ТЕЗ /** аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/ болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар ханган дүгнэлт өгөхөд энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлдэг байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын тоог хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/тоогоор/

Орон нутгийн төсвийн	Тусгай зориулалтын шилжүүлгийн	Төсөл сан	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	Төсвийн төвлөрүүлэн захирагч	Төсвийн ерөнхийлөн захирагч	Нийт
66	122	59	44	24	1	316

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлдэг 316 байгууллагаас 315 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулан, төсвийн шууд захирагч 118, төсөл сангийн 5 болон 4 ОНӨААҮГ-ын санхүүгийн тайлан, ТТЗ-ийн 24, ТЕЗ-ийн 1 санхүүгийн нэгтгэсэн тайланд бие даасан “Дүгнэлт” өгч, бусад 163 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулан баталгаажуулан ажиллалаа. “Түнэл-Ач” ОНӨААТҮГ-ын

санхүүгийн тайланг аудитад хамруулсан боловч тайланг баталгаажуулаагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд “Могойн гол” ХК ОНӨҮГ –аас бусад нэгтгэгдээгүй байгууллага байхгүй болно.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2017 оны 4 дүгээр сарын 01-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

1.3 Аудитын арга зүй

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмуудыг үндэслэж, байгууллагын дансдыг хамруулан түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын ба нарийвчилсан горимыг хэрэгжүүлэв.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 01-нээс 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн Аймгийн аудитын газрын СТА-ын багийн ахлах аудитор Л.Энх-Амгалан, аудитор Л.Магсаржалам нар гүйцэтгэв. /ТАБ-СТА-А-9/

1.4 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Аймгийн ИТХ-аар батлуулсан төсвийг хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна. Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36 “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Засаг дарга Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төсвийн ерөнхийлөн захирагч болон СТСХэлтсийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

ТЕЗ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэх үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 32 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлдэг сумдын ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангууд, АИТХ, АЗДТГ, БОАЖГ, аймгийн ХААА, ОНХС, ОНХО, Замын сан, Ахмадын асрамж үйлчилгээний төв зэрэг төсөвт байгууллагууд, Халамжийн сан, Мал хамгаалах сан, СХСан, Захиалагчийн хяналтын зардал зэрэг төсөл, сангууд, “Хөвсгөл дулаан”, “Хөвсгөл эрчим”, “Ус чандмань”, “УСНААК”, “Уран дөш хүүхдийн зуслан” ОНӨААТҮГ-ууд, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс зэрэг тусгай шилжүүлгийн байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ээр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангуудад аудит хийх явцад бидний анхаарлыг татсан санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийн талаарх алдаа, зөрчил, асуудлуудыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүгнэлтэд багтааж байгаа болно.

1.5. Санхүүгийн дотоод хяналт, аудит

Төсвийн тухай хуулийн 14.1.17-д заасны дагуу аймгийн Засаг дарга нь Төсвийн Ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн ерөнхийлөн захирагч орон нутгийн төсвийг аймгийн ИТХ-аар батлуулан жилийн төсвийг сар, улирлаар хуваарилан аймаг, сумын төрийн сангаар дамжуулан төсвийн төвлөрүүлэн захирагчид болон төсвийн шууд захирагч нарт олгож аймаг, сумдын төрийн сангийн төлөөлөгч нар дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 зааснаар дотоод аудитын албаны орон нутгийн төсвийн төлөвлөлт, орлого бүрдүүлэлт, аймгийн сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, ОНӨАҮГ-уудын үйл ажиллагаа зэрэгт эрсдлийн удирдлага, дотоод аудитын хяналт хангалтгүй байна.

1.6. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн батлагдсан маягтуудын дагуу “shilendans.gov.mn” нэгдсэн сайтын цахим хуудсанд холбогдох мэдээллүүдийг байршуулсан байна. Харин Сум хөгжүүлэх сангийн холбогдох мэдээллийг Khovsgol.gov.mn сайтын шилэн данс цэсэнд байршуулсан нь олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангахад төдийлөн хангалттай бус байна.

1.7. Материаллаг байдлыг тодорхойлох

Хөвсгөл аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнг суурь болгон авч түүний 2 хувиар тооцон 1944.9 сая төгрөгөөр тогтоов.

Хоёр. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

2.1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

2.1.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Төрийн сангийн харилцахын үлдэгдэл, байгууллага, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨҮГ-ууд, төсөл сангийн төгрөгийн харилцах дансдын үлдэгдэл,
- Кассад байгаа бэлэн мөнгө.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2015 оны эцэст 3763,7 сая төгрөг байснаас 2016 оны жилийн эцэст 36,4 хувиар өсч 5132,2 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 93,4 хувь буюу 4797.3 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	(сая төгрөгөөр) Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
Кассад байгаа бэлэн мөнгө	31.7	10.0	10.0		
Төгрөг /ЖМС/	31.7	10.0	10.0		
Гадаад валют					
Банкинд байгаа бэлэн мөнгө	3732.0	5090.5		293.2	4797.3
Төрийн сангийн харилцах	3520.0	4797.3			4797.3
Арилжааны банк	212.0	293.2		293.2	
Замд яваа мөнгө	0.0	31.8			
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	3763.7	5132.2	10.0	293.2	4797.3

Мөнгөн хөрөнгийг үлдэгдэл /байгууллагын төрлөөрх/

(сая төгрөгөөр)

ОН-ийн байгууллага	0.1	174.2	0.2	3.8	138.5
ОН-ийн ерөнхий орлого	2112.2	3225.0		1.9	3223.1
Сумын орлогын үлдэгдэл	1118.2	915.1			915.1
Аймгийн ерөнхий орлого: Үүнээс	994.1	2309.9			2309.9
Төсвийн шилжих үлдэгдэл	683.3	631.7			
Төсвийн хэмнэлт, зарцуулагдаагүй үлдэгдэл	1428.9	1678.2			
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	0.0	0.1	0.1		1435.8
ОНӨҮГ	243.4	296.3	8.8	287.4	0.0
Сангууд	629.1	770.3	1.0	0.0	770.3
Барьцаа хөрөнгө	522.6	666.5			666.5
Захиалагчийн хяналтын зардал	256.3	0.0			
Замд яваа мөнгө		31.8			
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	3763.7	5132.2	10.1	293.2	4797.3

Аймгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 2309.9 сая төгрөг, үүнээс шилжих үлдэгдэл 631.7 сая төгрөг, орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 138.5 сая төгрөг байна. Барьцаа хөрөнгийн харилцах дансанд 418,8 сая төгрөгийн хөрөнгө төвлөрсөн ба 59,0 сая төгрөгийн зарлага гарсан байна. Оны эхний 118,5 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн 2,2 сая

төгрөгийн барьцаа нь Барилгын тухай хуульд заасан 3 жилийн хугацаа хэтэрсэн хөрөнгө байна.

Төсвийн хэмнэлт, зарцуулагдаагүй үлдэгдэл 1678,2 сая төгрөг байна. Үүнд:

- Халамжийн тэтгэвэр тэтгэмж 1191.1 сая төгрөг
- Захиалагчийн хяналтын зардал 277.0 сая төгрөг,
- Орон нутгийн хөрөнгө оруулалт 129.5 сая төгрөг,
- АЗДТГ 33.5 сая төгрөг,
- БОАЖГ 32.4 сая төгрөг,
- Мал хамгаалах сан 15.7 сая төгрөг аймгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал арилжааны банкинд байршуулсан зардлын эх үүсвэрээс олгогдоогүй үлдсэн, зарцуулагдаагүй нийт 31.8 сая төгрөгийг Монгол банкнаас төрийн сангийн дансанд буцаан төвлөрүүлсэн боловч 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр төрийн сангийн дансанд байршаагүй тул замд яваа хөрөнгөөр бүртгэгдсэн байна.

2.1.2 Арилжааны банкин дахь харилцах дансны талаар

2016 оны жилийн эцэст арилжааны банкин дахь харилцах дансанд 293.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2.1.3 ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлийн талаар

Аудитаар мөнгөн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан, зөрүүтэй тайлагнасан, тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн, анхан шатны баримтгүй зарцуулсан зэргээс мөнгөн хөрөнгөтэй холбоотой нийт 460.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн болно. Аудитаар 24.6 сая төгрөгийн алдааг залруулж, 471.5 сая төгрөгтэй холбоотой ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилтийг харилцагч байгууллагатай тулган баталгаажуулаагүй, захиалагчийн дансаар дамжуулах болон тооцооны дансанд бүртгэж байх, гэрээгээр гүйцэтгэж байгаа ажлын гэрээг дүгнэж үлдэгдэл санхүүжилтийг олгох, анхан шатны баримтыг үндэслэн зарлага гаргах зэрэг зөвлөмжүүдийг ТШЗ нарт хүргүүлсэн болно.

2.2. Авлагын бүртгэл, тайлагнал

2.2.1 Авлагын бүтэц

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 8043,5 сая төгрөг байснаас тайлант онд 398,5 сая төгрөгөөр буурч, оны эцэст 7645,0 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Нийт авлагын 71,6 хувь буюу 5476,8 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн авлага байна. Авлагын бүтцийг авч үзвэл зээлийн авлага 4.1 сая төгрөгөөр, ажиллагсадтай холбоотой авлага 162.5 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 338.5 сая төгрөгөөр тус тус буурч, зээлийн хүүгийн авлага 75.4 сая төгрөгөөр, бусад авлага 31.6 сая төгрөгөөр тус тус өсчээ.

Нийт авлагын үлдэгдлийг бүтцээр нь харуулбал:

Авлагын төрөл	Эхний үлдэгдэл	(сая төгрөгөөр)	
		Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Ажиллагчидтай холбогдсон авлага	20.3	22.9	2.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	26.4	24.0	-2.4
Зээлийн хүүгийн авлага	47.6	123.0	75.4
Бусад авлага	393.8	425.4	31.6
Байгууллагаас авах авлага	1816.2	1477.7	-338.5
Хувь хүмүүсээс авах авлага	257.6	95.1	-162.5

Зээлийн авлага	5481.6	5476.8	-4.8
НИЙТ ДҮН	8043.5	7644,9	-398.6

Хүснэгтээс харвал зээлийн авлага болон байгууллагаас авах авлага 6954,4 сая төгрөг байгаа нь нийт авлагын 90.9 хувийг эзэлж байна. Байгууллагаас авах авлагын дүнд ХААН банкинд байршиж байгаа “Бүс орон нутгийн хөгжлийг дэмжих сан”, “Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”, “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ын 1065.7 сая төгрөгийн авлагыг бүртгэсэн ба өмнөх оноос 1.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Мал хамгаалах санд 107.0 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага 5476,8 сая төгрөг ба авлагын 32 хувь буюу **1808.8** сая төгрөг хугацаа хэтэрсэн зээлийн авлага байна.

Байгууллагаар нь авч үзвэл:

Байгууллага	Эхний үлдэгдэл	(сая төгрөгөөр)	
		Эцсийн үлдэгдэл	Зөрүү
ОН-ийн байгууллага	160.4	248.3	87.9
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	107.0	115.4	8.4
ОНӨҮГ	727.6	490.8	-236.8
Сангууд	7048.4	6790.5	-257.9
НИЙТ ДҮН	8043.4	7645.0	-398.4

Нийт авлагын 88.8 хувийг орон нутгийн сангуудийн авлага, 4.8 хувийг орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын авлага, 6.4 хувийг ОНӨҮГ-ын авлага эзэлж байна. ОНӨҮГ-ын 490,8 сая төгрөгийн авлагын 94.4 сая төгрөг “Хөвсгөл Эрчим хүч ХХК” 233.1 сая төгрөг “Хөвсгөл ус суваг ХХК” ОНӨҮГ-ын авлага байна.

Сангийн авлага /сан тус бүрээр/

Байгууллага	Эхний үлдэгдэл (сая төгрөгөөр)	Эцсийн үлдэгдэл (сая төгрөгөөр)
Байгаль хамгаалах сан	7.4	13.5
Мал хамгаалах сан	166.7	107.0
Сум хөгжүүлэх сан	6874.3	6670.0
Нийт дүн	7048.4	6790.5

Хүснэгтээс харвал: Сангийн авлагын 1.8 хувь буюу 120.5 сая төгрөгийг Байгал хамгаалах сан болон Малжуулах сангийн авлага, 98.2 хувь нь сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 6670.0 сая төгрөгийн авлага эзэлж байна.

2.2.2 ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар авлагатай холбоотой гарсан зөрчлийн талаар

Аудитаар авлагыг барагдуулаагүй, насжилтаар ангилан бүртгээгүй, үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, данс бүртгэлд орлого авалгүй шууд зардалд бүртгэсэн зэрэг нийт 115,2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Нийт зөрчлийн 23,7 сая төгрөгийг аудитын хугацаанд залруулж, 64,1 сая төгрөгийн зөрчилтэй холбогдуулан анхан шатны баримтыг үндэслэн бүртгэлд тусгах, авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай тулган баталгаажуулж байх, авлагыг насжилтаар бүртгэж барагдуулах арга хэмжээ авч ажиллах зэрэг зөвлөмжийг ТШЗ нарт хүргүүлэн ажиллалаа.

2.3. Бараа материалын бүртгэл, тайлагнал

2.3.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 6662,7 сая төгрөг байснаас тайлант онд 2372,5 сая төгрөгөөр өсч, оны

эцэст 9035,2 сая төгрөгөөр тайлагнасан байна. Нөөцийн барааны үлдэгдэл оны эхэнд 862,6 сая төгрөг, эцсийн байдлаар 32,0 сая төгрөг байна.

Бараа материалын үлдэгдэл /Байгууллагаар/

Байгууллагаар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая.төгрөгөөр)
			Зөрүү
ОН-ийн байгууллага	1,132.3	1,691.3	559.0
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	5,305.2	6,321.8	1,016.6
ОНӨҮГ	977.7	1,042.7	65.0
Сангууд	110.1	11.5	-98.6
НИЙТ ДҮН	7,525.3	9,067.3	1,542.0

Бараа материал тайлант жилд 14103,2 сая төгрөгөөр нэмэгдэж, 12561,3 сая төгрөгөөс буурсан байна.

Бараа материалын үлдэгдэл /дансдаар/

Бараа материалын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая.төгрөгөөр)	
			Зөрүү	Зөрүү хувь
Тусгай зориулалтын материал	752.0	1000.4	248.4	133.0
Эм боох материал	194.9	243.8	48.9	125.1
Бэлэн бүтээгдэхүүн	121.4	96.1	-25.3	79.2
Бичиг хэргийн материал	115.5	144.9	29.4	125.4
Аж ахуйн материал	2104.2	2525.3	421.1	120.0
Сэлбэг хэрэгсэл	368.4	326.0	-42.4	88.5
Түлш, шатах тослох материал	539.9	539.7	-0.3	100.0
Барилгын засварын материал	120.5	184.2	63.7	152.8
Хүнсний материал	604.1	663.4	59.3	109.8
Бусад хангамжийн материал	1428.7	3013.8	1585.1	210.9
Мал амьтад	313.1	297.8	-15.3	95.1
Дүн	6662,7	9035,2	2372,5	120.5

Бараа материалын дансдын үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад сэлбэг хэрэгсэл 11,5 хувиар, бэлэн бүтээгдэхүүн 20.8 хувиар, мал амьтад 4.9 хувиар тус тус буурсан, тусгай зориулалтын материал 33 хувиар, бичиг хэргийн материал 25,4 хувиар, барилгын засварын материал 110,9 хувиар өссөн нь төсөл арга хэмжээ, тоног төхөөрөмжийг барьж дуустал бусад бараа материал дансанд бүртгэсэн нь нийт бараа материалын дүнд нөлөөлөл үзүүлж байна.

2.3.2 Үнэ төлбөргүй авсан болон акталсан бараа материал

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 14103,2 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэний 2556,2 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй авсан байна. Тайлант онд 12561,3 сая төгрөгний бараа материал хасагдсанаас 1612,4 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн хассан байна.

2.3.3 ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бараа материалтай холбоотой гарсан зөрчлийн талаар

Аудитаар бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, данс, бүртгэлд орлого авалгүй шууд зардалд бүртгэсэн, бараа материалын хөдөлгөөний тайлан гаргаагүй, бараа материалыг анхан шатны баримтгүй зарцуулсан, тооллогод хамруулаагүй зэрэг нийт 51,0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Аудитаар 18,9 сая төгрөгийн зөрчлийг залруулж, Төсвийн шууд захирагч нарт 40,7 сая төгрөгийн зөрчилд НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-г мөрдөж ажиллах, анхан шатны баримтыг үндэслэн зарлага гаргах, аливаа урсгал засвар хийхдээ төсөв хийж байгууллагын удирдлагаар батлуулан ажиллах зэрэг зөвлөмж хүргүүлсэн болно.

2.4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

2.4.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгө 2015 оны эцэст 205552,1 сая төгрөг байснаас 8945.1 сая төгрөгөөр өсч, 214497.2 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгийн данс /байгууллагаар цэвэр дүнгээр/

(сая.төгрөгөөр)

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
ОН-ийн байгууллага	44,486.1	38,549.4	-5,936.7
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	71,211.8	78,622.6	7,410.8
ОНӨҮГ	23,034.2	23,502.3	468.1
Сангууд	2.6	1.8	-0.8
НИЙТ ДҮН	138,734.7	140,676.1	1,941.4

Нийт үндсэн хөрөнгийн 27.4 хувь нь Орон нутгийн байгууллагад, 55.9 хувь нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагад, 16,7 хувь нь ОНӨҮГ-ын санхүүгийн тайланд бүртгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

(сая.төгрөгөөр)

Үндсэн хөрөнгө	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Барилга байгууламж, орон сууц	150,275.2	160,953.1	10,677.92
Тээврийн хэрэгсэл	6,990.7	7,333.1	342.41
Машин тоног төхөөрөмж	18,401.4	19,658.7	1,257.25
Тавилга эд хогшил	5,679.5	6,127.2	447.68
Зам, гүүрийн байгууламж	6,514.6	6,496.9	-17.70
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	136.6	0.0	-136.60
Түүх соёлын дурсгалт зүйл	1,139.9	1,200.3	60.37
Дуусаагүй барилга байгууламж	6,976.8	1,942.1	-5,034.73
Номын фонд	1,746.1	1,800.0	53.91
Бусад үндсэн хөрөнгө	7,088.8	8,160.7	1,071.85
Програм хангамж	512.9	562.2	49.32
Бусад биет бус хөрөнгө	89.6	263.0	173.43
Дүн	205,552.1	214,497.2	8,945.1

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдэл өмнөх оноос 4.3 хувиар өссөн бөгөөд хөрөнгийн 99,6 хувийг биет хөрөнгө, 0,4 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Барилга байгууламж 7 хувиар, машин, тоног төхөөрөмж 6.8 хувиар тус тус өссөн байна. Дуусаагүй барилга 72,2 хувиар буурсан байна.

Цагаан-Үүр сумын ЗДТГ-ын дуусаагүй барилга дансанд 4500,0 сая төгрөгөөр бүртгэсэн Үүрийн голд тавьсан төмөр бетонон гүүрийг Зам тээврийн салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлан балансад бүртгэгдсэнтэй давхардсан тул аудитаар залруулж бүртгэлээс хасуулсан нь дуусаагүй барилга дансны буурсан дүнгийн 89.4 хувийг эзэлж байна.

Төсвийн захирагчид 2016 онд төсвийн хөрөнгөөр 1115.4 сая төгрөгөөр хөрөнгө бэлдэж мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний зардлын бүлгийн биет ба биет бус хөрөнгө худалдаж авсан зардлаар тайлагнасныг үндсэн хөрөнгийн тодруулгын тайлан дахь хөрөнгө худалдан авсан зардалтай тулгахад зөрүүгүй байна.

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр 1411.3 сая төгрөгийн хөрөнгө данснаас хассан нь үндсэн хөрөнгийн бууралтанд нөлөөлсөн байна.

2.4.2 Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 2016 оны эхэнд 66817,6 сая төгрөг байсан. Тайлант хугацаанд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 9353.6 сая төгрөг, данснаас хасагдсан хөрөнгийн элэгдэл 4214.3 сая төгрөгөөр буурч оны эцэст 73820.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тайлагнагдсан байна.

2.4.3 Үнэ төлбөргүй авсан болон акталсан үндсэн хөрөнгө

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 23579.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс 1115.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авсан, 67.2 сая төгрөгийг хандив тусламжаар, 8209.3 сая төгрөгийг шилжүүлэн авсан, 14154.7 сая төгрөгийн хөрөнгийг бусад эх үүсвэрээс шилжүүлэн авсан байна.

2016 онд 14635.4 сая төгрөгний үндсэн хөрөнгө данснаас хасагдсанаас эрх бүхий байгууллагын шийдвэрээр 1411.3 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 13224.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн болон данснаас хассан байна.

2.4.4 Шилжүүлж авсан үндсэн хөрөнгө

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 22396.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад эх үүсвэрээр шилжүүлэн авч үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

2.4.5 ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлийн талаар

Аудитаар үндсэн хөрөнгийг бүртгээгүй, шийдвэргүй хөрөнгө бэлтгэсэн, данснаас хассан зэргээс ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой 419,1 сая төгрөгийн зөрчил илэрч аудитаар 90,1 сая төгрөгийн алдааг залруулав. “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18.2-ыг хэрэгжүүлж НБББББ-т үндсэн болон биет бус хөрөнгөнд элэгдэл байгуулах талаар тодорхой тусгаж ажиллах, байгууллагад бүртгэлтэй байгаа программ хангамжийн болон хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, тооллогыг чанартай бодитоор тоолж үлдэгдлийг баталгаажуулж байх, үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэх зэрэг 368,7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ТШЗ нарт хүргүүлсэн болно.

2.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт өр төлбөр 2015 оны эцэст 6649,4 сая төгрөг байснаас 546,1 сая төгрөгөөр буурч, тайлант онд 6098,1 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Үүнээс урт хугацаат өр төлбөр 3217,3 сая төгрөг байна.

2.5.1 Өр төлбөрийн бүтцийн талаар

/ сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
ОН-ийн байгууллага	980.0	1325.4	345.4
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	847.9	56.0	-791.9
ОНӨҮГ	4214.5	3993.1	-221.4
Сангууд	607.0	723.6	116.6
НИЙТ ДҮН	6,649.40	6,098.1	-551.3

Нийт өр төлбөрийн 65.4 хувийг ОНӨААҮГ-ын өр төлбөр эзэлж байгаа бөгөөд үүний 3993,1 сая төгрөгийн өр төлбөрөөс “Хөвсгөл Эрчим хүч ХХК” ОНӨҮГ 1208.9 сая төгрөг, “Хөвсгөл ус суваг ХХК” ОНӨҮГ 2617.4 сая төгрөгийн өр төлбөр байна.

Орон нутгийн байгуулагуудын өр төлбөр 21.7 хувийг эзэлж байгаа бөгөөд Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн өр 666.4 сая, Хот тохижилт үйлчилгээний төв 136.3 сая төгрөг, аймгийн ерөнхий орлогод төвлөрүүлсэн санхүүжилтийн өглөг 222.5 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтын өр төлбөр 112.9 сая төгрөг зэрэг байна.

2.5.2 ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар өр төлбөртэй холбоотой гарсан зөрчлийн талаар

Аудитаар батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан, барьцаа хөрөнгийг өглөгөөр бүртгээгүй, гэрээний үүрэгтэй холбоотой өглөг бүртгээгүй зэргээс ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өр төлбөртэй холбоотой 45,7 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба аудитын хугацаанд 37.2 сая төгрөгийн өглөгийг залруулсан болно. Төсвийг үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, гэрээний үүргээ биелүүлж ажиллах зэргээр 43,9 сая төгрөгийн зөрчилд ТШЗ нарт зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

2.6.Орлого, татаас санхүүжилтийн бүртгэл, тайлагналын талаар

2.6.1 Улсын төсвийн орлого

Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг батлагдсан төлөвлөгөөгөөр 19161,4 сая төгрөг, гүйцэтгэлээр 19161,4 сая төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлэг төлөвлөгөөгөөр 54257,6 сая төгрөг, гүйцэтгэлээр 54257,6 сая төгрөг, ОНХС-ын орлогын шилжүүлэг 3395,6 сая төгрөг, гүйцэтгэлээр 3395,6 сая төгрөгөөр тус тус татаас санхүүжилтийн орлого бүрдэж, тусгай зориулалтын шилжүүлэг 268,8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж төсвийн гүйцэтгэлээр 53979,7 сая төгрөгөөр тайлагнасан байна.

2.6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Хөвсгөл аймгийн 2016 оны төсвийн орлого, эх үүсвэрийг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас 91994.9 сая төгрөгөөр баталсан. Аймгийн орон нутгийн орлогын төлөвлөгөө 505,9 сая төгрөгөөр тасарсан байна. Сум хөгжүүлэх сангийн эргэж төлөгдөх зээл 1828.0 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 39.6 сая төгрөгөөр төлөвлөгөө биелээгүй байна. Орон нутгийн татварын орлого 1302.2 сая төгрөгөөр, татварын бус орлого 59.5 сая төгрөгөөр төлөвлөгөө давсан байна.

Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Өмнөх оны байдлаар	нэгдсэн тайлангаар		Зөрүү	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	дүн	хувь
Татварын орлого	8674.5	8430.1	9732.3	1302.2	115.4
Татварын бус орлого	702	489.1	548.7	59.5	112.2
Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг	18005.1	19161.4	19161.4	0.0	100.0
ОНХС-ын орлогын шилжүүлэг	4573.2	3395.6	3395.6	0.0	100.0
Тусгай зориулалтын шилжүүлэг	48740.5	54248.6	53979,7	268,9	100
Төсвийн шилжих үлдэгдэл	2384.4	2679,8			0.0
Эргэж төлөгдөх зээл		3031,2	1182,6	-1828,0	43,9
Төсөвт байгууллагын өөрийн орлого	0	559.1	519.5	-39.6	92.9
Дүн	83079.7	91994.9	88519,8	505,9	96.5

Өмнөх онтой харьцуулахад: Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө 457.3 сая төгрөгөөр буурсан, гүйцэтгэлээр 505,9 сая төгрөгөөр өссөн байна. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Нийт дүн	Үүнээс
----------	----------	--------

		БСШУ-ын сайд	ХАХНХ-ын сайд	ЭМС-ын сайд	БХБСайд
Батлагдсан төсөв	54467.8	47843.0	270.2	6099.6	254.9
Олгосон урсгал санхүүжилт	54248.5	47630.5	263.5	6099.6	254.9
Нийт төвлөрүүлсэн	268.8	263.7	0	4.7	0.4
Үүнээс: Төсөвт /Сангийн яам/	268.8	263.7	0	4.7	0.4

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтэд 54467.8 сая төгрөг батлагдсанаас 54248,5 сая төгрөгийг зарцуулж, 268,8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө 219.2 сая төгрөг, гүйцэтгэлээр 215.5 сая төгрөг байна.

2.6.3 Өөрийн орлого

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар төсөвт газрын өөрийн орлого 559.1 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс, гүйцэтгэлээр 519.5 сая төгрөг орж, 39.6 сая төгрөгөөр дутуу буюу 92,9 хувийн биелэлттэй байна.

2.6.4 Татварын орлого

Хөвсгөл аймгийн 2016 оны ТЕЗ-ийн орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн урсгал төсвийн орлого гүйцэтгэлээр 10846.3 сая төгрөг, үүнээс татварын буцаан олголт 1114.0 сая төгрөгийг хасч тооцоход 9732.3 сая төгрөгөөр тайлагнасан, орлогын гүйцэтгэл 115.4 хувиар буюу 1302.2 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл:

Сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөг дараах сумдууд 100.5-305 хувиар биелүүлсэн байна.

- Үүнд: Аймгийн орлого-109.8/, Алаг-Эрдэнэ-117.7%, Арбулаг-127.4%, Баянзүрх-115.7%, Бүрэнтогтох-119.4%, Галт -165.3%, Жаргалант-166.2%, Их уул-128.4%, Рашаант-125%, Рэнчинлхүмбэ-112.3%, Тариалан-305%, Тосонцэнгэл-143.5%, Төмөрбулаг-109%, Түнэл-109.6%, Цагаан-Уул-107.5%, Цэцэрлэг-194.5%, Чандмань-Өндөр-109.3%, Шинэ-идэр-114.9%, Мөрөн-101.9%, Эрдэнэбулган-100.5%

Дараах сумдууд 3.5-33.5 хувиар орон нутгийн орлогын төлөвлөгөөг тасалсан байна.

- Улаан-Уул-88.6%, Ханх-66.5%, Цагаан-үүр-81.6%, Хатгал-96.5%, Цагааннуур- 3.5 % байна.

2.6.5 ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар орлого, үр дүнтэй холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

Аудитаар орон нутгийн орлогыг төлөвлөгөөг биелүүлээгүй, төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан, орлогын тайланг буруу илэрхийлсэн зэрэг нийт 173,8 сая төгрөгийн зөрчил илэрч, 79,6 сая төгрөгийн алдааг залруулж, 137,9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

2.7. Зардлын бүртгэл, тайлагналын талаар

2.7.1 Санхүүжилтийн зарцуулалтын талаар

Хөвсгөл аймгийн ТЕЗ-ийн төсвийн 2016 онд зарцуулах зарлагыг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас нийт 91994.9 сая төгрөгөөр баталсан. Төсвийн гүйцэтгэлийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн нийт төсвийн зардал

91994.9 сая төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 87723.2 сая төгрөг зарцуулсан нь батлагдсан төлөвлөгөөнөөс 4271.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Орон нутгийн төсөв, гүйцэтгэл

сая төгрөгөөр

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны байдлаар	Нэгтгэсэн тайлангаар		
			төлөвлөгөө	гүйцэтгэл	эзлэх хувь
1	Аймгийн Засаг дарга	32219	34022.0	32290.5	36.81
2	БСШУСайдын ТЗШ	41876.1	47776.9	47509.3	54.16
3	БХБСайдын ТЗШ	253.8	254.9	254.5	0.29
4	НХХСайдын ТЗШ	275.4	270.2	270.2	0.31
5	Эрүүл мэндийн сайдын ТЗШ	6465.5	6099.6	6095.2	6.95
6	Төсөл сан	81089.8	3,571.20	1,303.50	1.48
	Дүн	81089.8	91,994.9	87,723.2	100



Хөвсгөл аймгийн ТЕЗ-ийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг зориулалтаар авч үзвэл нийт зарлагын 36.9 хувийг аймгийн Засаг даргын, 54.2 хувийг БСШУСайдын ТЗШ, 6,9 хувийг Эрүүл мэндийн сайдын ТЗШ-д зарцуулсан байгаа нь нийт зарлагын 98,0 хувийг эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулахад: Батлагдсан төлөвлөгөө 10905.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлээр 6633.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийг сайдын ТЗШ-ээр авч үзвэл:

- Батлагдсан төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 1937.2 сая төгрөгөөр, БСШУСайдын ТЗШ 267.6 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн ТЗШ 4.5 сая төгрөгөөр нийт 4284.8 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.
- Аймгийн засаг даргад хамаарах Нийгмийн халамжийн зардалд 14426.3 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 13232.5 сая төгрөг болж 1193.8 сая төгрөг зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвийн нийт зардлыг бүтцээр нь харуулбал:

/сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэлээр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Эзлэх хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81089.76	91994.95	87723.3	100
УРСГАЛ ЗАРДАЛ	75008,89	83795,68	81896.4	93,3
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58718,09	64342,7	63658.6	72,6
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	40689,06	41127,8	41023,2	46,8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4425,3	4622,5	4592,7	5,2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5648,76	6977,2	6904,7	7,9
Хангамж, бараа материалын зардал	1571,25	2009,49	1986.8	2,3

Нормативт зардал	3327,05	4257,78	4204,1	4,8
Эд хогшил, урсгал засварын зардал	550,16	1042,86	1039,17	1,2
Томилолт, зочны зардал	224,29	219,28	212,19	0,2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	509,42	1516,76	1208,3	1,4
Бараа үйлчилгээний бусад зардал	1772,80	2569,02	2487,38	2,8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6080,87	4941,54	4644,28	5,3
ТАТААС	278.0	689,99	689,99	0,8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		18762,9	17547,8	20,0
Үүнээс: НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	12252,03	14426,28	13232,57	15,1
Эргэж төлөгдөх зээл	0	3257.7	1182.6	1.3

Дээрх хүснэгтээс харахад нийт зардалд бараа үйлчилгээний зардал 72.6 хувь, хөрөнгийн зардал 5.3 хувь, татаасын зардал 0,8 хувь, урсгал шилжүүлэг 20 хувийг тус тус эзэлж байна.

2016 оны төсвийн хэтрэлт хэмнэлтийг зардлын зүйл ангиар авч үзвэл:

- Цалин, шимтгэл, тогтмол зардал, хоол зэрэг нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, хангамж, бараа материалын зардал зэрэг урсгал зардлуудыг батлагдсан төлөвлөгөөнөөс 23,70-320,62 сая төгрөгөөр, нийгэм халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал нь 1193,71 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 297,26 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

2.7.2. Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд 3295.9 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж 117.8 сая төгрөгийг аймаг, сумын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

2.7.3. Тусгай шилжүүлгийн зарцуулалт

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол
- Ерөнхий боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ
- Газрын харилцаа, кадастр
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

ЭМС, ХАХНХС, БХБЯ, БСШУС-ын төсөвт батлагдсан тусгай зориулалтын шилжүүлгийн 54467.8 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу санхүүжүүлсэн байна.

Тусгай шилжүүлэгтэй холбоотойгоор хөрөнгийн задаргаа
(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Нийт дүн		Үүнээс:			
	2015 онд	2016 онд	ЭМС-ын сайд	ХАХНХ-ын сайд	БСШУ-ын сайд	БХБСайд
Мөнгөн хөрөнгө	0.1	0.1	0.1			
Авлага	107.0	115.8	1.0	7.7	107.1	
Бараа материал	4,605.6	6321.8	514.6	24.2	5,757.7	25.3
Нөөцийн бараа	700.4	0.0			0.0	
Үндсэн хөрөнгө	71,382.9	78622.6	6020.6	1,172.4	70,777.2	652.4
Нийт хөрөнгийн дүн	76,796.0	85,060.3	6,536.3	1,204.3	76,642.0	677.7
Өр төлбөр	850.166	56.0	17.3	1.8616	36.9	0.0

Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	75,945.8	85,004.3	6,519.0	1,202.4	76,605.1	677.7
Өр төлбөр цэвэр хөрөнгө/өмчийн дүн	75,945.8	85,004.3	6,519.0	1,202.4	76,605.1	677.7
	76,796.0	85,060.3	6,536.3	1,204.3	76,642.0	677.7

Хүснэгтээс харахад: Бараа материал 1716.2 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө 7239.7 сая төгрөгөөр, цэвэр хөрөнгө 6519.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, өр төлбөр 794.2 сая төгрөгөөр буурсан байна.

2.7.4. Тусгай сангийн зарцуулалт

Хөвсгөл аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 24 сумын 52 сан, аймгийн 5 сан нийт 57 тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Сумдын Байгал хамгаалах сан, Орон нутгийн хөгжлийн сан, Мал хамгаалах сан, Сум хөгжүүлэх сангийн бүртгэлийн дансанд Төрийн санд байршиж үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр сангуудын тайлант оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1151.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1610.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Касст байгаа	Замд яваа	(сая төгрөгөөр) Банкинд байгаа бэлэн мөнгө	
					Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
Халамжийн сан	0	35.3		31.8	3.5	0
Байгаль хамгаалах сан	78.4	30.2				30.2
Мал хамгаалах сан	151.6	142.9				142.9
Орон нутгийн хөгжлийн сан	118.8	138.5				138.5
Барьцаа хөрөнгө	522.6	666.5				666.5
Сум хөгжүүлэх сан	280.2	597.1	1,0			596,1
Нийт дүн	1151.6	1610.5	1,0	31.8	3.5	1574,2

Тайлант онд сум хөгжүүлэх сангийн, орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл сангуудын нийт үлдэгдлийн 45.6 хувийг эзэлж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт.

Хөвсгөл аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2016 онд хийж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймгийн ИТХ-ын 2015 оны 12-р сарын 03-ны 03 дугаар тогтоолоор баталсан, 2016 оны 4 дүгээр сарын 6-ны 01 дүгээр тогтоол, 2016 оны 9 дүгээр сарын 23-ны 01 дүгээр тогтоолоор тодотгон баталснаар 3676,9 сая төгрөгийн төсөв баталсан байна. Үүнээс ОНХНС-аас санхүүжих 3395.6 сая төгрөг, аймгийн орлогоос 281.6 сая төгрөгөөр төсөв бүрдүүлж, 3645.6 сая төгрөгийг зарцуулж, аймгийн ОНХСангийн хувьд оны эцэст 51.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 6.1 заалтын дагуу аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа, дуусаагүй ажлуудыг бусад бараа материалын дансанд орлого авсан. Үүнд:

№	Ажлын нэр	Дүн мян төг
1	Мөрөн-Түнэл сумын хэсэгчилсэн төлөвлөгөө	58500,0
2	Тосонцэнгэл сумын сургуулийн ариун цэврийн байгууламж	45000,0
3	Мөрөн сумын усан сангийн байгууламжийн өргөтгөл	77000,0
	Нийт дүн	180500,0

Мөрөн-Түнэл сумын хэсэгчилсэн төлөвлөгөө нь 2016 онд 58.50 сая төгрөг батлагдсан боловч санхүүжилтийг

олгогдоогүй, ОНХС-ийн тайланд өглөгөөр толилуулсан байна.

Аймгийн ИТХ-аар ОНХСангийн төсвийг дараах байдлаар баталсан байна.

Хурлын шийдвэрийн огноо, дугаар	Баталсан дүн (мян.төг)			Үүнээс	
	ОНХНСан гаас	Орон нутгаас	Нийт	Аймаг	Сум
2015 оны 12 сарын 03, №03	4,435,988.7	79,756.9	4,515,745.6	1,806,298.3	2,709,447.3
2016 оны 04 сарын 06, №01		201,592.0	201,592.0	201,592.0	
2016 оны 9 сарын 23, № 01	-1,040,387.8		-1,040,387.8	-416,155.1	-624,232.7
Дүн	3,395,600.9	281,348.9	3,676,949.8	1,591,735.2	2,085,214.6

2015 онд улсын төсвөөс ирэх орлогын шилжүүлэг 919.7 сая дутуу ирснээс шалтгаалан аймгийн төсөвт өр үүссэн тул өр барагдуулах үүднээс Төсвийн тухай хуулийн 34.2.2 заалтыг үндэслэн аймгийн ИТХ-аар 2016 оны төсөвт 4 дүгээр сард тодотгол хийсэн. Уг тодотголоор аймгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 2015 оны орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн дутууг нөхөж 201,6 сая төгрөгийг нэмж баталсан байна.

2016 оны 9 дүгээр сард улсын төсөвт тодотгол хийгдэж орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 1040,4 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

2.7.5. ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардал, үр дүнтэй холбоотой гарсан зөрчлийн талаар

Аудитаар төсвийн зарцуулалт, эдийн засгийн ангилалтай холбоотой нийт 228.5 сая төгрөгийн зөрчил илэрч, 56,3 сая төгрөгийн алдааг залруулан 144,3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

2.8. Эзэмшигчийн өмчийн талаар

2.8.1 Засгийн газрын хувь оролцоо

(сая төгрөгөөр)

Засгийн газрын хувь оролцоо	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
ОН-ийн байгууллага	47,050.4	42,711.4	-4,339.0
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	75,776.2	85,004.3	9,228.1
ОНӨҮГ	20,768.5	21,339.0	570.5
Сангууд	7,843.3	7,548.9	-294.4
НИЙТ ДҮН	151,438.4	156603,9	5,165,5

Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл өмнөх оноос 5165,5 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар өсч 156603,9 сая төгрөг болсон байна.

Засгийн газрын хувь оролцоог бүтцээр авч үзвэл орон нутгийн байгууллагын үлдэгдэл 4.3 сая төгрөгөөр буурсан, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд 9.2, ОНӨААҮГ-ийн Засгийн газрын сан 0.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

2.8.2. Хуримтлагдсан үр дүнгийн талаар

АТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Хуримтлагдсан үр дүнгийн оны эхний үлдэгдэл 29333.2 сая төгрөг, тайлант хугацааны үр дүн 5525.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 2016 оны эцэст 34859,0 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

2.8.3. Дахин үнэлгээний нөөцийн талаар

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дахин үнэлгээний нөөц нь үндсэн хөрөнгө данснаас хассантай холбоотойгоор 96.8 сая төгрөгөөр буурч, 2016 оны эцэст 17975.7 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

2.9. Хөрөнгө оруулалтын талаар

2016 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 19 төсөл, арга хэмжээнд 334.1 сая төгрөг батлагдсан, гүйцэтгэлээр 209.3 сая төгрөг бөгөөд аймгийн Ерөнхий орлогын дансанд 129.5 сая төгрөгийг төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалтын тайланд 112.9 сая төгрөгийг өглөгөөр бүртгэж тайлагнасан байна.

Гурав. Орон нутгийн төсөв болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын аудитын дүнгийн талаар

3.1 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын талаар

Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан сая төгрөгөөр

Үзүүлэлт	Нийт дүн		Үүнээс:			
	2015 онд	2016 онд	ЭМС-ын сайд	ХАХНХ-ын сайд	БСШУ-ын сайд	БХБСайд
Мөнгөн хөрөнгө	0.1	0.1	0.1			
Авлага	107.0	115.8	1.0	7.7	107.1	
Бараа материал	4,605.6	6321.8	514.6	24.2	5,757.7	25.3
Нөөцийн бараа	700.4	0.0			0.0	
Үндсэн хөрөнгө	71,382.9	78622.6	6020.6	1,172.4	70,777.2	652.4
Нийт хөрөнгийн дүн	76,796.0	85,060.3	6,536.3	1,204.3	76,642.0	677.7
Өр төлбөр	850.166	56.0	17.3	1.8616	36.9	0.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	75,945.8	85,004.3	6,519.0	1,202.4	76,605.1	677.7
Өр төлбөр цэвэр	75,945.8	85,004.3	6,519.0	1,202.4	76,605.1	677.7
хөрөнгө/өмчийн дүн	76,796.0	85,060.3	6,536.3	1,204.3	76,642.0	677.7

3.1.1. Эрүүл мэндийн байгууллагууд:

Эрүүл мэндийн салбарын 18 сумын эрүүл мэндийн төвүүд, 5 өрхийн эмнэлгүүд нь 2016 онд 6099.6 сая төгрөгийн санхүүжилт авахаас 6099.6 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч зарцуулсан байна. Тус байгууллагуудын авлагын үлдэгдэл 1.0 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 17.3 сая төгрөг байна.

3.1.2 Боловсролын байгууллагууд:

Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын 36 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 42 цэцэрлэг, соёлын төв 23, насан туршийн боловсролын төв нийт 102 байгууллага тусгай зориулалтын шилжүүлэгээр улсын төсвийн санхүүжилт 47761.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 81.4 сая төгрөг бүгд 47843.0 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Салбарын хэмжээгээр авлага 107.1 сая төгрөг, өглөг 36.9 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогын гүйцэтгэл 84.6 сая төгрөг байна. Үүнээс соёлын төвүүдийн өөрийн орлогын төлөвлөгөө 31.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 31.4 сая төгрөг байна.

Дөрөв. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Хөвсгөл аймгийн Орон нутгийн төсвийн шууд захирагчийн 192 байгууллагын 68.2 хувь буюу 131-н ТЗШилжүүлгийн байгууллага ба 31,8 хувь буюу 56 орон

нутгийн төсвийн байгууллага байна. Орон нутгийн байгууллагын төсвийн шууд захирагчийн 31 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан болно.

Хөвсгөл аймгийн Орон нутгийн 56 байгууллага аудитад хамрагдсанаас 55 байгууллагын санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгч ажилласан.

Хөвсгөл аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлдэг ТШЗ, Төсөл сан, ОНӨҮГ-уудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлүүдийг хавсралт №2-оор харуулав.

Тав.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аймгийн хэмжээнд Ерөнхий аудиторын баталсан хуваарийн дагуу 24 төсвийн төвлөрүүлэн захирагч, 1 ТЭЗ-ийн санхүүгийн тайланд аудит хийх төлөвлөгөөтэйгээс батлагдсан хуваарийн дагуу бүрэн хамрууллаа.

Зургаа. Орон нутгийн сан, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Хөвсгөл аймгийн төсөл сангийн тайланд 24 сумын орон нутгийн хөгжлийн сан, 23 сумын сум хөгжүүлэх сан болон аймгийн сум хөгжүүлэх сан зэрэг 57 сан, төсөл хөтөлбөрүүдийн 2016 оны жилийн эцсийн тайланг аудитад хамрууллаа.

А. Сумдын “Сум хөгжүүлэх сан”-гийн талаар: Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагатай холбоотой 1808.8 сая төгрөгийн зөрчил илэрч, зөвлөмж хүргүүлэв.

Б. Захиалагчийн хяналтын зардлын аудитын талаар: Захиалагчийн хяналтын зардлаас нийт 7,1 сая төгрөгөөр бичиг хэргийн материал худалдаж авсан, аймгийн ХААА-ны интернетийн төлбөрт 2,2 сая төгрөг зэрэг нийт 9.3 сая төгрөгийг зарцуулж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлын гүйцэтгэлээр тайлагнасан байна. Дээрх зардлуудыг зориулалтын бус зүйлд зарцуулсан бөгөөд гүйцэтгэгч байгууллагын дансаар дамжуулаагүй шууд зарцуулсан нь гүйцэтгэгч байгууллагын бүртгэлд тусгаагүй, орлого аваагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.6 “бүх зардал” гэсэн нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын батлагдсан төсөв 115.3 сая төгрөг, гүйцэтгэлээр 28.5 сая төгрөг ба 277,1 сая төгрөгийг аймгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

В. “Аймгийн сум хөгжүүлэх сан”-гийн аудитын талаар: ХААН банкин дахь нийт 1065,7 сая төгрөгийн зээлийн эх үүсвэрийг тусгайлсан данс нээж байршуулаагүйгээс зээлийн эргэн төлөлт, сангийн эх үүсвэр, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээг хянах боломжгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн ХААН банк дахь үлдэгдэл оны эхний байдлаар 379,4 сая төгрөг, жилийн эцсийн байдлаар 316,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гэж ХААН банк тооцоог ирүүлдэг боловч тусгайлсан дансгүй тул тулган баталгаажуулах боломжгүй байна.

Аймгийн засаг даргын ХААН банкны Хөвсгөл салбарын захиралтай байгуулсан гэрээний 2.3-т “Зээлийн сангийн мөнгөн хөрөнгөд гэрээний хугацаанд хүү тооцохгүй” гэж тусгаснаар мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэлд хүү тооцож аваагүй, зээлийн хүү жилийн 7 хувь гэж зааснаар зээлийн хүүгийн орлого ХААН

банкны ашиг болж байгаа зэрэг зөрчилтэй холбогдуулан аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Тайлант онд төрийн санд байршиж буй дансанд 1 зээлдэгчтэй холбоотой төвлөрсөн зээлийн 1,3 сая төгрөгийн хүүгийн орлогоор сангийн эх үүсвэр нэмэгдсэн байна.

Г. Мал хамгаалах сангийн аудитын талаар: Мал хамгаалах сангийн өвс тэжээлийн 2012-2014 онд үүссэн гэрээний хугацаа дууссан авлага 47.1 сая төгрөг, 2015 онд үүссэн авлага 22.0 сая төгрөг бүгд 69.1 сая төгрөг, 2016 онд шинээр үүссэн 40.6 сая төгрөгийн авлагатай, өвс тэжээлийн хэвийн хорогдол 2016 онд 744 боодол буюу 14,88 тн 5.2 сая төгрөг тооцож бүртгэлээс хассан боловч устгалт хийгдээгүй байна.

Д. “Засаг дарга” дансны аудитын талаар: Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 заалтыг зөрчиж АИТХ-ын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан төсвийн тодотголоор “Засаг дарга” дансанд 20.9 сая төгрөгийг баталж, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээг нэмж санхүүжүүлсэн байна.

Долоо. ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд болон төсвөөс санхүүгийн дэмжлэг авч буй нийт 40 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхээс 39 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийсэн болно. Аудитаар нийт 459.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 77.0 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Найм. Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн аймгийн орон нутгийн байгууллагууд болон ЕБС-иуд, төсөл сангийн санхүүгийн тайланд 100 хувь аймгийн аудитын газрын аудитор, шинжээч нар, бусад тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд болон ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд гэрээгээр хараат бус аудитын компаний аудитор нар аудитыг хийсэн.

Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөгөөгөөр нийт 316 байгууллагад аудит хийх төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 315 байгууллагад аудит хийгдэж “Түнэл-Ач” ОНӨААТҮГ санхүүгийн тайланг тайлан хоцроож ирүүлсэн тул баталгаажуулаагүй болно. Аудитаар 118 байгууллага, 24 ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан, 5 төсөл сангийн тайлан, 2 ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаснаас 2 тайланд буюу 1.3 хувьд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 149 байгууллага, төсөл сан, ОНӨААТҮГ-ын буюу 98.7 хувьд нь “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна. “Хөвсгөл дулаан ХХК”, “Хөвсгөл ус чандмань ХХК”, “УСНААК ХХК” ОНӨААТҮГ –ууд татан буугдсантай холбогдуулан 2016 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаарх дуусгалтын тайланг баталгаажуулсан боловч санал дүгнэлт гаргаагүй болно.

Аудитаар нийт 3302,6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 330,6 сая төгрөгийн алдааг залруулж, орон тоо хэтрүүлэн ажиллуулсантай холбогдуулан албан шаардлага хүргүүлэн, 3080,2 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлсэн.

№	“Хязгаарлалттай” дүгнэлт авсан байгууллага	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Ханх сумын ЗДТГ	Ханх сумын ЗДТГ-ын шууд захирагч нь Үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 19900,0 мянган төгрөгийн авто машин биетээр оршихгүй, дутагдуулан шүүхийн шийдвэрээр барьцаанд хураалгасан, 11,6 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, 7,5 сая төгрөгийн насжилттай авлага барагдуулахгүй байгаа зэрэг зөрчил нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2	Ханх сумын ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан	Ханх сумын ТТЗ санхүүжилт 20164,7 мянган төгрөгөөр тасарсан байна. Ханх сумын ИТХурлын тогтоол гарч тэмдэгтийн хураамжийг төрийн сангаар дамжуулаагүй шууд зарцуулснаас /Хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байгаа/ сумын ОН Орлого тасарсан байна. Орон нутгийн орлого 28651,6 мянган төгрөгөөр тасарсан ба үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 19900,0 мянган төгрөгийн авто машин биетээр оршихгүй, дутагдуулан шүүхийн шийдвэрээр барьцаанд хураалгасан зэрэг зөрчил нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Орон нутгийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг тайлангийн 11 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан 32 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлбол: Зарим төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан дахь *“Орон нутгийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, гүйцэтгэл буруу гаргасан, төсөвт байгууллагын өөрийн орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй, бүртгэлд бүртгээгүй төлбөр төлсөн, ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүрэн бүртгээгүй, өглөг, авлагын үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй, хөрөнгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй зэрэг/ зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Арав. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан балансын дансдын үлдэгдлийг түүвэрлэн тулган шалгасан ба санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй аудитад хамрагдаагүй дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлдэг сумдын ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангууд, АИТХ, АЗДТГ, БОГ, аймгийн Засаг дарга, Халамжийн сан зэрэг төсөвт байгууллагууд, Мал хамгаалах сан, СХСан, Захиалагчийн хяналтын зардал зэрэг төсөл сангууд, “Хөвсгөл дулаан”, “Хөвсгөл эрчим”, “Усчандмань”, “УСНААК”, “Хөвсгөл Ус суваг”ХХК, ОНӨААТҮГ-ууд, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, зэрэг тусгай шилжүүлгийн

байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ээр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангуудад аудит хийх явцад бидний анхаарлыг татсан санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийн талаарх алдаа, зөрчил, асуудлуудыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүгнэлтэд багтааж байгаа болно.

2016 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Монгол улсын Ерөнхий аудиторов А/72 дугаар тушаалаар Хөвсгөл аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлдэг байгууллагуудын хувьд итгэл үзүүлсэн байгууллага байхгүй байна.

Могойн гол ХК нь Компаний тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 заалтын дагуу аудит хийх хараат бус аудитын компанийг ТУЗ-аар сонгон шалгаруулж 2016 оны санхүүгийн тайлангаа баталгаажуулсан байна.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнгийн талаар болон аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөө 115.2 хувийн гүйцэтгэлтэй буюу 1361.7 /8919.2-10280.9/ сая төгрөгөөр давж биелсэн ч бууны албан татвар 16.6 хувиар буюу 14.3 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлого 64.6 хувиар буюу 45.3 сая төгрөгөөр, хувьцааны ногдол ашиг 32.1 хувиар буюу 20.0 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 5.7 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 7.1 хувиар буюу 39.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.
2. Ханх сум тэмдэгтийн хураамжийн орлогоо төрийн сан дах орлогын дансанд төвлөрүүлээгүй данснаас гадуур зарцуулагдсанаас орон нутгийн орлого тасарсан байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь, 41 дүгээр зүйлийн 41.2.1 заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5 заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

3. Цагааннуур сумын ЕБС - Бага үнэтэй, түргэн элэгдэх, зүйлс зардлын гүйцэтгэл 18,0 сая төгрөг, үүнээс 12.5 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн, Цагаан-Уул сумын ЗДТГ - тээвэр шатахууны зардлаас 6,0 сая төгрөгөөр өвс тэжээл бэлтгэсэн, Хатгал тосгоны ЕБС - хичээл үйлдвэрлэлийн зардлаас 4.9 сая төгрөгийн зардлыг, БҮТЭЗардлаас 8.2 сая төгрөгийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй зэрэг зөрчил нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж байх, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалтай нийцүүлэн зарцуулж байх зөвлөмж хүргүүлэв.

4. “Хөвсгөл дулаан ХХК” ОНӨҮГ-ын ТУЗ-ийн шийдвэрээр ОХУ-ын Буриад улсын Түнхэн аймагт нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх сургалт, зохион байгуулах, сургалтын бэлтгэл ажил хангуулах, ТУЗ-ийн

гишүүдийг ОХУ-ын Буриад улсын Түнхэн аймагт ажиллах зардал гаргах, ажилчдыг ОХУ-ын Буриад улсын Улаан-Үүд хотын дулааны станцын шугам сүлжээ, техник технологийн шинэчлэлттэй танилцаж, туршлага судлах, үндсэн хөрөнгө бэлтгэх зэрэгт 39.3 сая төгрөгийн зардал гаргаж батлагдсан зардлыг хэтрүүлсэн, Компаний тухай хуулийн 76 дугаарт заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хэтрүүлсэн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9.1 заалтыг үндэслэн ОНӨҮГ-уудын төсвийн үр ашгийг дээшлүүлэн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг төсөвт төвлөрүүлэхээр орон нутгийн төсөв батлуулж гүйцэтгэлийг хангуулан ажиллах.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн ТУЗ-ын гишүүд Компаний тухай хуулийн 76 дугаарт заасан зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллаж батлагдсан төлөвлөгөөний хүрээнд зардал гаргах, түүнд тавих хяналтыг сайжруулан ажиллах зөвлөмж хүргүүлэв.

5. “Хөвсгөл ус суваг ХХК” ОНӨҮГ –ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5.1 км буюу 234.6 сая төгрөгийн /үлдэх өртөг-107.8 сая төг/-ийн үнэтэй цэвэр усны шугам сүлжээний хөрөнгө дутагдсан, биетээр оршин байхгүй байна. Хуучин шугам сүлжээг тухайн үед комисс томилогдож хүлээж аваагүйгээс хөрөнгө аудитаар биетээр дутагдаж байна. Улмаар татан буугдсан компаниудын хөрөнгө хүлээлцэх ажлын хэсэг хөрөнгийг баталгаажуулаагүй, дутагдсан хөрөнгийг шийдвэрлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 заалтыг үндэслэн орон нутгийн өмчийн хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулах, дутагдсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.

6. “Бүс орон нутгийн хөгжлийг дэмжих сан, Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан болон Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”-ийн ажиллах гэрээнд: Банк дамжуулан олгосон зээл эргэн төлөгдөөгүйгээс үүдэн гарах аливаа хохирлыг банк хариуцахгүй, Зээлийн сангийн мөнгөн хөрөнгөнд хүү тооцохгүй, Олгосон зээл эргэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд ХААН банкнаас эх үүсвэрийг буцаан татахгүй гэсэн нөхцөлтэйгээр аймгийн Засаг дарга, ХААН банкны Хөвсгөл салбарын захирал нарын хийсэн гэрээний дагуу зээлийн хүүгийн орлого тооцогдохгүй байна. Жилийн эцэст 316.3 сая төгрөгийн эх үүсвэр тус банкинд чөлөөт үлдэгдлээр байршиж байна.

Шийдвэрлэсэн: АИТХ-ын 2016 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоолыг үндэслэн зээлийн хөрөнгийн орлого, зарлагыг сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд тусгах, Арилжааны банкт хийсэн гэрээнд өөрчлөлт оруулах, зээлийн үлдэгдлийг харилцагч бүрээр тулган баталгаажуулж, зээлийн чөлөөт үлдэгдлийг зориулалтын дагуу зарцуулж сангийн зорилтыг ханган ажиллах зөвлөмж хүргүүлэв.

7. АТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангаар сум хөгжүүлэх сангийн эргэж төлөгдөх зээлийн төлбөр 3257.7 сая төгрөг, гүйцэтгэлээр 36.3 хувь буюу 1182.6 сая төгрөг байна. Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1808,8 сая төгрөг нь төсвийн гүйцэтгэлд нөлөөлөл үзүүлсэн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дах заалтыг мөрдөж, төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангуулж байх.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.2. Сангийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг тухайн аймгийн Засаг дарга хэрэгжүүлнэ” заалтыг удирдлага болгон ажиллах зөвлөмж хүргүүлэв.

8. АТЕЗ санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнг аудит хийсэн дүнтэй тулгахад авлага 7,0 сая төгрөг, өглөг 20.7 сая төгрөгөөр, Засгийн газрын хувь оролцоо 13.5 сая төгрөгөөр буюу нийт 41.23 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 заалтыг үндэслэн аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг зөвшөөрч бүртгэсэн, аудит хийгдсэн санхүүгийн тайланг хянан нэгтгэж байх зөвлөмж хүргүүлэв.

9. Мал хамгаалах сангийн өвс тэжээлийн 2012-2016 онуудад үүссэн нийт 109.7 сая төгрөгийн авлагын 63 хувь нь өмнөх жилүүдээс дамжиж ирсэн он дамжсан авлага байгаа бөгөөд барагдуулах арга хэмжээ аваагүй, Мал хамгаалах сангийн өвс тэжээлийн хэвийн хорогдлоор 2016 онд 744 боодол буюу 14,88 тн 5.2 сая төгрөг тооцож бүртгэлээс хассан боловч устгалт хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2-заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 12.2.6 заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 заалт жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө болон бусад тохиолдолд хөрөнгө өр төлбөрийг тоолж баталгаажуулж байх заалтуудыг хэрэгжүүлэн хөрөнгө, өр төлбөрийг тооллогоор баталгаажуулж байх зөвлөмж хүргүүлэв.

10. Арбулаг, Цагааннуур, Эрдэнэбулган сумын ЭМТөвүүд “Цахим эрүүл мэнд хөтөлбөр-өөр ЭМЯ-аас 2012 онд нийлүүлсэн тус бүр 15.5 сая төгрөгийн программ хангамжийг одоо болтол ашиглаагүй атлаа тайлант онд 30.2 сая төгрөгийн элэгдэл байгуулж байгууллагын үр дүн бууруулсан МУ-ын “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 12.2, 20.2.24 заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Эрүүл мэндийн төвүүдэд “Цахим эрүүл мэнд хөтөлбөр”-өөр хэрэгжүүлсэн цахим програмын ашиглалтыг сайжруулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Материаллаг бус алдаа зөрчил:

Аудитаар нийт 2734,2 сая төгрөгийн материаллаг бус алдаа, зөрчил илэрсэн болно.

Арван хоёр. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад материаллаг болон материаллаг бус алдаанаас санхүүгийн тайланд **330,6** сая төгрөгийн алдааг залруулж, хууль, журам, заавар мөрдөөгүйгээс шалтгаалан гарсан **639,3** сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

Арван гурав. Анхаарал татахуйц асуудлын талаар

- Ханх сумын ТТЗ-ийн тэмдэгтийн хураамжийн орлогыг төрийн сан дах орлогын дансанд төвлөрүүлээгүй данснаас гадуур зарцуулсан байна.
- Ханх сумын ЗДТГ үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа Монгол мал хөтөлбөрөөр бэлтгэгдсэн 19.9 сая төгрөгийн авто машиныг тус сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Баасансүрэнгийн нэхэмжлэлийн дагуу ШШГАлбаны шийдвэр гүйцэтгэгч хураан авснаар хөрөнгө дутагдсан байна.
- Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 заалтыг зөрчиж АИТХ-ын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан төсвийн тодотголоор Шүүхийн шийдвэрийг үндэслэн 20.9 сая төгрөгийг МСҮТ-ийн дадлагын байрны засварын ажлын үлдэгдэл санхүүжилтэд баталж, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээг нэмж санхүүжүүлсэн.
- “Хөвсгөл ус суваг ХХК” ОНӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5.1 км буюу 234.6 сая төгрөг/үлдэх өртөг-107,8 сая төг/ -ийн үнэтэй цэвэр усны шугам сүлжээний хөрөнгө дутагдсан байна.
- Халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 1191.1 сая төгрөг байгаа зэргээс өөр **анхаарал татахуйц чухал асуудал** үгүй байна.

Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад Бүс орон нутгийн хөгжлийг дэмжих сангийн, Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн болон Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн зээлийн эргэн төлөлт, Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын эргэн төлөлт болон “Хөвсгөл Ус суваг ХХК” ОНӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5.1 км буюу 234.6 сая төгрөгийн үнэтэй цэвэр усны шугам сүлжээ биетээр оршин байхгүй байгааг шийдвэрлэсэн эсэхийг дараагийн аудитаар авч үзэх болно.

Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт **3302,6** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс **330,6** сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын хугацаанд залруулан ажиллаж, **3080,2** сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, аймгийн Засаг даргын орлогч 1 ажиллахаас 2 ажиллаж **орон тоо хэтрүүлэн ажилласантай холбогдуулан** зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын хариуг ирүүлээгүй болно.

Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газрын харьяа Хөвсгөл аймгийн аудитын газрын хийсэн аудитаар нийт 7 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 85 хувийг хэрэгжүүлж, 15 хувийг буюу 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс аудитаар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрсэн шинж чанарын хувьд материаллагаар тооцсон **568,4** сая төгрөгийн зөрчил нь өмнөх оны санхүүгийн тайлангаар илэрсэн шинж чанарын хувьд материаллаг зөрчлөөс буурсан боловч аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийж ажиллаагүй, ерөнхий нягтлан бодогчид эрх үүргээ хэрэгжүүлээгүй зэргээс алдаа зөрчил давтагдсаар байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан, санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан, мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан, өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Хөвсгөл аймгийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Аймгийн засаг дарга болон Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд, Ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхтуяа болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

<i>Асуудал 1: Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар</i>	<i>Тэргүүлэх ач холбогдол №1</i>
---	---

ААГ-ын ажиглалт

-Орон нутгийн орлогын төлөвлөгөө 115.2 хувийн гүйцэтгэлтэй буюу 1361.7 /8919.2-10280.9/ сая төгрөгөөр давж биелсэн ч бууны албан татвар 16.6 хувиар буюу 14.3 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлого 64.6 хувиар буюу 45.3 сая төгрөгөөр, хувьцааны ногдол ашиг 32.1 хувиар буюу 20.0 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 5.7 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 7.1 хувиар буюу 39.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

- Ханх сумын тэмдэгтийн хураамжийн орлого төрийн сан дах орлогын дансанд төвлөрүүлээгүй данснаас гадуур зарцуулагдсан учраас орон нутгийн орлого тасарсан байна.

ААГ-ын зөвлөмж

1. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь, 41 дүгээр зүйлийн 41.2.1 заалтуудыг мөрдөж, төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангуулж байх.
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5 заалтыг хэрэгжүүлэн “бүх орлогыг” заавал бүртгэнэ заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

Эрсдэл

Орлогыг үнэн зөв төлөвлөж бүртгэхгүй байх нь төсвийн сахилга алдагдах, зардлын эх үүсвэр дутагдахад хүрнэ.

Төсвийн захирагчийн хариу

АЗД-ын 06 тоот албан даалгавар гаргаж, төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг

хангуулах талаар заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Асуудал 2: Зардлын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
----------------------------------	----------------------------------

ААГ-ын ажиглалт

Цагааннуур сумын ЕБС - Бага үнэтэй, түргэн элэгдэх, зүйлс зардлын гүйцэтгэл 18,0 сая төгрөг, үүнээс 12.5 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн, Цагаан-Уул сумын ЗДТГ - тээвэр шатахууны зардалд мал хамгаалах сангийн 6,0 сая төгрөгийг зарцуулсан, Хатгал тосгоны ЕБС - хичээл үйлдвэрлэлийн зардлаас 4.9 сая төгрөгийн зардлыг, БҮТЭЗардлаас 8.2 сая төгрөгийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй зэрэг зөрчил нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Эрсдэл

1.Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх нь үргүй зардал гаргах эсрдэлтэй

ААГ-ын зөвлөмж

йн 3.Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалтыг хэрэгжүүлэн батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж байх,
4. Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалтай нийцүүлэн зарцуулж байх.

Төсвийн захирагчийн хариу

Зардлын эдийн засгийн ангиллыг баримтлах талаар төсөв захирагч нарт зөвлөмж хүргүүлэн ажиллах болно.

Асуудал 3: ТУЗ-ийн шийдвэр, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ААГ-ын ажиглалт

Хөвсгөл дулаан ХХК” ОНӨҮГын ТУЗ-ийн шийдвэрээр ОХУ-ын Буриад улсын Түнхэн аймагт нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх сургалт, зохион байгуулах, сургалтын бэлтгэл ажил хангуулах, ТУЗ-ийн гишүүдийг ОХУ-ын Буриад улсын Түнхэн аймагт ажиллах зардал гаргах, ажилчдыг ОХУ-ын Буриад улсын Улаан-Үүд хотын дулааны станцын шугам сүлжээ, техник технологийн шинэчлэлттэй танилцаж, туршлага судлах, үндсэн хөрөнгө бэлтгэх зэрэгт 39.3 сая төгрөгийн зардал гаргаж батлагдсан төсвийн зардлыг хэтрүүлсэн байна.

Эрсдэл

Батлагдсан төсвийг хүрээнд орон нутгийн өмчийн хөрөнгийг зарцуулахгүй байх нь орон нутгийн хөрөнгийн үр ашиг алдагдахад хүргэнэ. Х. Э ба Ү,

ААГ-ын зөвлөмж

5.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9.1 заалтыг үндэслэн ОНӨҮГ-уудын төсвийн үр ашгийг дээшлүүлэн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг төсөвт төвлөрүүлэхээр орон нутгийн төсөв батлуулж гүйцэтгэлийг хангуулан ажиллах.
6. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн ТУЗ-ын гишүүд Компаний тухай хуулийн 76 дугаарт заасан зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллаж батлагдсан төлөвлөгөөний хүрээнд зардал гаргах, түүнд тавих хяналтыг сайжруулан ажиллах.

Төсвийн захирагчийн хариу

		ОНӨҮГ-уудын үр ашгийг дээшлүүлэх, зардлыг бууруулах талаар ТУЗ-уудад чиглэл өгч ажиллаж байна.
Асуудал 4: Үндсэн хөрөнгийн талаар		Тэргүүлэх ач холбогдол №2
<u>ААГ-ын ажиглалт</u>		<u>ААГ-ын зөвлөмж</u>
“Хөвсгөл ус суваг ХХК” ОНӨҮГ –ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5.1 км буюу 234.6 сая төгрөгийн /үлдэх өртөг-107807.6 мян.төг/ -ийн үнэтэй цэвэр усны шугам сүлжээний хөрөнгө дутагдсан, биетээр оршин байхгүй байна.		7. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дах “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө болон бусад тохиолдолд хөрөнгө өр төлбөрийг тоолж баталгаажуулж байх заалтуудыг хэрэгжүүлэн хөрөнгө, өр төлбөрийг тоолж баталгаажуулж байх” заалтыг үндэслэн орон нутгийн өмчийн хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулах, дутагдсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.
<u>Эрсдэл</u>		<u>Төсвийн захирагчийн хариу</u>
Санхүүгийн тайланг холбогдох заавар журмын дагуу гаргахгүй байх нь тайлан хэрэглэгчдийн буруу мэдээллээр хангах эрсдэлтэй.		Дутагдсан хөрөнгийн асуудлыг судалж шийдвэрлэнэ.
Асуудал 5: Аймгийн сум хөгжүүлэх сангийн талаар		Тэргүүлэх ач холбогдол №2
<u>ААГ-ын ажиглалт</u>		<u>ААГ-ын зөвлөмж</u>
“Бүс орон нутгийн хөгжлийг дэмжих сан”, “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан” болон “Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”-ийн ажиллах гэрээнд: Банк дамжуулан олгосон зээл эргэн төлөгдөөгүйгээс үүдэн гарах аливаа хохирлыг банк хариуцахгүй, Зээлийн сангийн мөнгөн хөрөнгөнд хүү тооцохгүй, Олгосон зээл эргэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд ХААН банкнаас эх үүсвэрийг буцаан татахгүй гэсэн нөхцөлтэйгээр аймгийн Засаг дарга, ХААН банкны Хөвсгөл салбарын захирал нарын хийсэн гэрээний дагуу зээлийн хүүгийн орлого тооцогдохгүй байна. Жилийн эцсийн байдлаар 316.3 сая төгрөгийн эх үүсвэр тус банкинд чөлөөт үлдэгдлээр байршиж байна.		8. АИТХ-ын 2016 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоолыг үндэслэн зээлийн хөрөнгийн орлого, зарлагыг сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд тусгах, арилжааны банктай хийсэн гэрээнд өөрчлөлт оруулах 9. Зээлийн үлдэгдлийг харилцагч бүрээр тулган баталгаажуулж, зээлийн чөлөөт үлдэгдлийг зориулалтын дагуу зарцуулж сангийн зорилтыг ханган ажиллах.
		<u>Төсвийн захирагчийн хариу</u>
		Эх үүсвэрийн данснаас зарлага гаргах боломжгүй, банкны салбарын НББОУС-аар

Эрсдэл

Санхүүгийн тайланг холбогдох заавар журмын дагуу гаргахгүй байх нь тайлан хэрэглэгчдийн буруу мэдээллээр хангах эрсдэлтэй.

зохицуулагдаж байгаа асуудал болно. Мөн ХААН банк эрсдлийг дааж байгаа тул хүүгийн орлогыг манай тал авахгүйгээр гэрээ байгуулсан болно.

Асуудал 6: Сум хөгжүүлэх сангийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>ААГ-ын ажиглалт</u> АТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангаар сум хөгжүүлэх сангийн эргэж төлөгдөх зээлийн төлбөр 3257.7 сая төгрөг, гүйцэтгэлээр 36.3 хувь буюу 1182.6 сая төгрөг байгаа нь сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1808.8 сая төгрөг байна.	<u>ААГ-ын зөвлөмж</u> 10.Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14,2.3 дах заалтыг мөрдөж, төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангуулж ажиллах. 11. Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.2. Сангийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг тухайн аймгийн Засаг дарга хэрэгжүүлнэ” заалтыг удирдлага болгон ажиллах. <u>Төсвийн захирагчийн хариу</u> Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.
Асуудал 7: Санхүүгийн нэгтгэсэн тайлан	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>ААГ-ын ажиглалт</u> АТЕЗ санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнг аудит хийсэн дүнтэй тулгахад авлага 7,0 сая төгрөг, өглөг 20.7 сая төгрөгөөр, Засгийн газрын хувь оролцоо 13.5 сая төгрөгөөр буюу нийт 41.2 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн байна.	<u>ААГ-ын зөвлөмж</u> 12.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 зугаар зүйлийн 20.2.10. заалт “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалтын дагуу аудит хийгдсэн санхүүгийн

тайланг нэгтгэж, хяналт тавьж ажиллах.

Эрсдэл

Аудитаар баталгаажсан тайлангийн дүнгээр санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргахгүй байх нь хэрэглэгчдэд хүрэх тайлан зөрүүтэй илэрхийлэгдэх эрсдэлтэй. Э ба Ү, Т, О, Х

Төсвийн захирагчийн хариу

Түүвэрт хамрагдсан байгууллагуудын тайлангийн дүнд алдаа гарснаар, мөн буруу илэрхийлсэн тайланг аудитаар илрүүлээгүйтэй холбоотой аудит хийгдсэн зарим тайлангийн дүн өөрчлөгдсөн болно.

Асуудал 8: Мал хамгаалах сангийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>ААГ-ын ажиглалт</u> Мал хамгаалах сангийн өвс тэжээлийн 2012-2016 онуудад үүссэн нийт 109.7 сая төгрөгийн авлагын 63 хувь нь өмнөх жилүүдээс дамжиж ирсэн он дамжсан авлага байгаа бөгөөд барагдуулах арга хэмжээ аваагүй, Мал хамгаалах сангийн өвс тэжээлийн хэвийн хорогдолоор 2016 онд 744 боодол буюу 14,88 тн 5.2 сая төгрөг тооцож бүртгэлээс хассан боловч устгалт хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2- заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 12.2.6 заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	<u>ААГ-ын зөвлөмж</u> 13.Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 заалт жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө болон бусад тохиолдолд хөрөнгө өр төлбөрийг тоолж баталгаажуулж байх заалтуудыг хэрэгжүүлэн хөрөнгө, өр төлбөрийг тооллогоор баталгаажуулж байх.
<u>Эрсдэл</u> Өр, авлагын үлдэгдлийг тулган баталгаажуулахгүй, төлж барагдуулахгүй байх нь төсвийн хөрөнгө үрэгдэж шамшигдах эрсдэлтэй.	<u>Төсвийн захирагчийн хариу</u> Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.
Асуудал 9: Үндсэн хөрөнгийн ашиглалтын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>ААГ-ын ажиглалт</u>	<u>ААГ-ын зөвлөмж</u>

Арбулаг, Цагааннуур, Эрдэнэбулган сумын ЭМТөв Цахим эрүүл мэнд хөтөлбөрөөр ЭМЯ-аас 2012 онд нийлүүлсэн тус бүр 15.5 сая төгрөгийн программ хангамжийг одоо болтол ашиглаагүй атлаа тайлант онд 30.2 сая төгрөгийн элэгдэл байгуулж байгууллагын үр дүн бууруулсан МУ-ын "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 12.2, 20.2.24 заалтуудыг зөрчсөн байна.

Эрсдэл

Санхүүгийн тайланг холбогдох заавар журмын дагуу гаргахгүй байх нь тайлан хэрэглэгчдийн буруу мэдээллээр хангах эрсдэлтэй.

14.Эрүүл мэндийн төвүүдэд "Цахим эрүүл мэнд хөтөлбөр"-өөр хэрэгжүүлсэн цахим програмын ашиглалтыг сайжруулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах.

Төсвийн захирагчийн хариу

ЭМЯ-ны програм хангамжийн хяналтын хороо цахим програмыг хүлээж аваагүй, ашиглаагүй өдийн хүрсэн байна. Дэлхийн банкны төслөөр цахим эрүүл мэнд хөтөлбөр хэрэгжихээр болжуг програмыг ашиглах боложгүй болсон.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ОЮУНГЭРЭЛ Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ Огноо: 2017.04.19

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Л.ЭНХ-АМГАЛАН Огноо: 2017.04.17
Л.МАГСАРЖАЛАМ Огноо: 2017.04.17

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
Эргэлтийн хөрөнгө		19353089.17	22025960.54
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3а,3б	3,763,691.92	5,132,269.23
Авлага	5а,5б,6а,6б	8,043,518.58	7,645,006.26
Урьдчилгаа	7а,7б	20,568.69	935.45
Бараа материал	8а,8б,8в	6,662,695.15	9,035,246.60
Нөөцийн бараа	9а	862,614.83	32,003.00
Бусад эргэлтийн хөрөнгө			180,500.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		138,734,689.29	140,676,079.81
Үндсэн хөрөнгө	12а,12б,12в	138,734,689.29	140,676,079.81
Биет хөрөнгө		138,337,948.62	140,087,705.51
Биет бус хөрөнгө	13	396,740.67	588,374.30
Нийт хөрөнгийн дүн		158,087,778.46	162,702,040.35
Богино хугацаат өр төлбөр	15а, 15б	2,998,334.52	2,880,857.85
Богино хугацаат зээлийн өглөг	16а,16б	406,113.01	-
Өглөг	17а, 17б	2,584,102.90	2,867,857.13
Урьдчилж орсон орлого	18а, 18б	8,118.61	13,000.72
Урт хугацаат өр төлбөр	19	3,651,062.86	3,217,277.77
Урт хугацаат зээл	20а, 20б	3,651,062.86	3,217,277.77
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		151,438,381.08	156,603,904.74
Засгийн газрын байгууллагын хувь оролцоо		151,438,381.08	156,603,904.74
Хуримтлагдсан үр дүн		29,333,191.83	34,859,036.51
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		18,072,559.02	17,975,704.76
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн нийт дүн		158,087,778.46	162,702,040.36

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		151,982,040.87	102,456,342.06
ТАТВАРЫН ОРЛОГО		8,674,508.71	9,732,277.62
Орлогын албан татвар		5,892,456.55	6,165,607.91
Хувь хүний орлогын албан татвар		6,826,948.15	7,279,653.61
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(943,222.50)	(1,114,045.70)
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил,үйлчилгээ хувиараа эрхлэгч		8,730.90	-
Хөрөнгийн албан татвар		791,030.59	923,529.49
Бусад татвар, төлбөр ,хураамж		1,991,021.57	2,643,140.22
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	45,819,920.65	33,387,657.39
Нийтлэг татварын бус орлого		27,762,403.32	14,191,905.99
Хөрөнгийн орлого		52,380.00	34,345.70
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		18,005,137.33	19,161,405.70
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		97,487,611.51	59,336,407.05
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	135,364,941.26	93,907,849.00
УРСГАЛ ЗАРДАЛ		129,036,369.71	91,343,447.53
БАРАА,АЖИЛ ҮЙЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		69,952,412.64	73,656,711.44
Цалин хөлс болон нэмэгдэл ,урамшил		40,872,644.33	41,047,128.80
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,484,223.94	4,538,212.72
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		5,930,035.28	6,511,624.28
Хангамж бараа материалын зардал		2,071,216.45	2,217,619.52
Нормативт зардал		3,931,124.11	3,773,883.41
Эд хогшил ,урсгал засварын зардал		674,942.29	1,051,986.59
Томилолт, зочны зардал		328,185.53	231,117.91
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,650,126.16	2,561,175.25
Бараа үйлчилгээний бусад зардал		10,009,914.55	11,723,962.96
ТАТААС		278,800.00	411,187.70
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		58,805,157.07	17,275,548.39
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		6,328,571.55	2,564,401.47

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		16,617,099.61	8,548,493.06
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		42,429.27	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		519,815.98	3,325,875.74
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		16,139,712.90	5,222,617.32

АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ мянган төгрөг/-өөр

Тайлангийн үзүүлэлт	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	136,371,092.82	103,068,981.85
ТАТВАРЫН ОРЛОГО	8,674,508.71	9,732,277.61
Орлогын албан татвар	5,892,456.55	6,165,607.91
Хувь хүний орлогын албан татвар	6,826,948.15	7,279,653.61
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(943,222.50)	(1,114,045.70)
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил,үйлчилгээ хувиараа эрхлэгч	8,730.90	-
Хөрөнгийн албан татвар	791,030.59	923,529.49
Бусад татвар, төлбөр ,хураамж	1,991,021.57	2,643,140.21
Бусад нийтлэг төлбөр, хураамж	708,807.71	566,148.28
Газрын төлбөр	289,279.56	239,381.52
Байгалийн нөөц ашигласны төлбөр	990,113.41	1,830,716.84
Бусад татвар	2,820.89	6,893.57
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,177,006.79	32,073,978.27
Нийтлэг татварын бус орлого	12,119,489.46	12,878,226.87
Хөрөнгийн орлого	52,380.00	34,345.70
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	18,005,137.33	19,161,405.70
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,519,577.32	61,262,725.97
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	129,488,477.67	95,398,472.57
УРСГАЛ ЗАРДАЛ	129,488,477.67	95,398,472.57
БАРАА,АЖИЛ ҮЙЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,499,949.68	77,102,492.57
Цалин хөлс болон нэмэгдэл ,урамшил	43,452,323.44	43,807,105.31
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,013,216.02	5,282,563.35

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,101,224.52	7,361,204.77
Хангамж бараа материалын зардал	7,170,003.30	8,416,828.36
Нормативт зардал	3,345,998.96	4,260,029.93
Эд хогшил ,урсгал засварын зардал	577,039.09	1,141,177.83
Томилолт, зочны зардал	347,773.05	233,827.25
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,733,095.45	2,836,011.80
Бараа үйлчилгээний бусад зардал	2,759,275.85	3,763,743.97
ТАТААС	278,800.00	411,187.70
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,709,727.99	17,884,792.30
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	6,882,615.15	7,670,509.28
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,313,389.09	1,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	7,421,670.68	5,085,626.28
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,421,670.68	5,085,626.28
Дотоод эх үүсвэрээр	7,421,670.68	5,085,626.28
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(6,108,281.59)	(5,084,626.28)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(1,801,484.60)	(1,217,305.70)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,801,484.60	1,182,601.20
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	34,704.50
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,027,151.06)	1,368,577.31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,790,842.98	3,763,691.92
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,763,691.92	5,132,269.23

АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ мянган төгрөг/-өөр

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	136,258,680.42	136,258,680.42
НБББ-ын өөрчлөлт	21,638,970.64	21,638,970.64
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	157,897,651.06	157,897,651.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(28,610.95)	(28,610.95)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	(22,570,371.92)	(22,570,371.92)
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал/	16,139,712.89	16,139,712.89
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	151,438,381.08	151,438,381.08
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	151,438,381.08	151,438,381.08
НБББ-ын өөрчлөлт	39,760.60	39,760.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,478,141.68	151,478,141.68
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(96,854.26)	(96,854.26)
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал/	5,222,617.31	5,222,617.31
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	156,603,904.73	156,603,904.73

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,994,948.50	87,723,252.59	4,271,695.91	95.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	83,795,684.60	81,896,368.71	1,899,315.89	97.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,342,726.60	63,658,558.62	684,167.98	98.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,127,815.90	41,023,244.17	104,571.73	99.75
210101	Үндсэн цалин	36,528,524.40	36,528,019.72	504.68	100.00
210102	Нэмэгдэл	548,983.50	520,115.01	28,868.49	94.74

210103	Унаа хоолны хөнгөлөлт	127,588.10	93,448.77	34,139.33	73.24
210104	Урамшуулал	2,344,696.30	2,308,126.55	36,569.75	98.44
210105	Гэрээт ажлын хөлс	1,578,023.60	1,573,534.11	4,489.49	99.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,622,501.50	4,592,745.19	29,756.31	99.36
210201	Тэтгэврийн даатгал	2,978,303.40	3,036,814.22	-58,510.82	101.96
210202	Тэтгэмжийн даатгал	328,765.70	309,563.41	19,202.29	94.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	409,490.00	377,353.69	32,136.31	92.15
210204	Ажилгүйдлийн даатгал	84,008.70	93,173.40	-9,164.70	110.91
210205	Эрүүл мэндийн даатгал	821,933.70	775,840.45	46,093.25	94.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,977,200.60	6,904,704.32	72,496.28	98.96
210301	Гэрэл, цахилгаан	485,469.80	484,507.02	962.78	99.80
210302	Түлш, халаалт	6,196,765.90	6,177,904.85	18,861.05	99.70
210303	Цэвэр, бохир ус	289,630.30	236,957.85	52,672.45	81.81
210304	Байрны түрээс	5,334.60	5,334.60	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,009,493.30	1,986,794.57	22,698.73	98.87
210401	Бичиг хэрэг	167,065.40	173,306.66	-6,241.26	103.74
210402	Тээвэр, шатахуун	957,179.60	950,446.56	6,733.04	99.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,025,396.00	181,284.61	1,844,111.39	8.95
210404	Ном, хэвлэл	77,138.60	70,127.59	7,011.01	90.91
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	138,390.80	135,418.97	2,971.83	97.85
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	467,179.30	476,210.17	-9,030.87	101.93
2105	Нормативт зардал	4,257,784.70	4,204,069.44	53,715.26	98.74
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	241,471.40	251,537.85	-10,066.45	104.17
210502	Хоол, хүнс	3,569,709.80	3,500,372.55	69,337.25	98.06
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	446,603.50	451,859.03	-5,255.53	101.18
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,042,861.90	1,039,172.53	3,689.37	99.65
210601	Багаж, техник, хэрэгсэл	111,196.00	101,978.37	9,217.63	91.71
210602	Тавилга	88,342.60	87,907.85	434.75	99.51
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,526.00	2,763.34	762.66	78.37
210604	Урсгал засвар	839,797.30	846,522.97	-6,725.67	100.80
2107	Томилолт, зочны зардал	219,278.00	212,194.88	7,083.12	96.77
210701	Гадаад албан томилолт	1,000.00	234.00	766.00	23.40
210702	Дотоод албан томилолт	216,988.00	210,673.98	6,314.02	97.09
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,290.00	1,286.90	3.10	99.76
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,516,765.20	1,208,253.52	308,511.68	79.66

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,452,556.90	1,149,860.97	302,695.93	79.16
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	20,120.10	17,617.00	2,503.10	87.56
210803	Даатгалын үйлчилгээ	9,033.20	8,740.08	293.12	96.76
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,578.60	6,321.10	257.50	96.09
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,508.40	1,254.58	253.82	83.17
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,073.20	14,164.36	908.84	93.97
210807	Газрын төлбөр	3,444.80	3,319.46	125.34	96.36
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,450.00	6,975.95	1,474.05	82.56
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0		0.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,569,025.50	2487379.98	81,645.52	96.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,984,331.90	1,912,969.78	71,362.12	96.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	584,693.60	574,410.19	10,283.41	98.24
211	ХҮҮ	0		0.00	
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0	0	0.00	
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0	0	0.00	
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0	0	0.00	
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0	0	0.00	
212	ТАТААС	689,987.70	689,987.00	0.70	100.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	278,800.00	278,800.00	0.00	100.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	278,800.00	178,800.00	100,000.00	64.13
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	411,187.70	411,187.70	0.00	100.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	411,187.70	411,187.70	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,762,970.30	17,547,822.39	1,215,147.91	93.52
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	483,882.50	483,882.50	0.00	100.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	483,882.50	483,882.50	0.00	100.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0	0	0.00	

2132	Бусад урсгал шилжүүлэг	18,279,087.80	17,063,939.89	1,215,147.91	93.35
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0	0	0.00	
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	14,426,282.40	13,232,572.88	1,193,709.52	91.73
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,481.80	30,473.37	8.43	99.97
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,252,578.20	1,240,203.25	12,374.95	99.01
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	5,258.80	4,950.46	308.34	94.14
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,682,482.30	1,680,216.16	2,266.14	99.87
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	781,655.10	777,863.55	3,791.55	99.51
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,349.20	97,660.20	2,689.00	97.32
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,941,545.10	4,644,282.68	297,262.42	93.98
220001	Барилга байгууламж	0	0	0.00	
221001	Их засвар	0	0	0.00	
222001	Тоног төхөөрөмж	0	0	0.00	
223001	Бусад хөрөнгө	4,941,545.10	4,644,282.68	297,262.42	93.98
224001	Стратегийн нөөц хөрөнгө	0	0	0.00	
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,257,718.80	1,182,601.20	2,075,117.60	36.30
230001	Эргэж төлөгдөх зээл	3,257,718.80	1,182,601.20	2,075,117.60	36.30
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	0	0	0.00	
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	0	0	0.00	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	91,994,948.50	88,127,144.66	3,867,803.84	95.80
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	57,644,184.10	57,375,354.90	268,829.20	99.53
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	0.00	
310002	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	0	0	0.00	
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	54,248,583.20	53,979,754.00	268,829.20	99.50
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	3,395,600.90	3,395,600.90	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,080,635.40	28,791,839.93	-711,204.53	102.53
320001	Орон нутгийн төсвөөс	28,080,635.40	28,791,839.93	-711,204.53	102.53

320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0		0.00	
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0	0.00	
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0	0	0.00	
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0	0	0.00	
34	ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0	0.00	
340001	Хүний хөгжил сангийн төсвөөс санхүүжих	0	0	0.00	
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,238,898.10	530,269.76	2,708,628.34	16.37
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	529,032.40	460,113.53	68,918.87	86.97
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,090.80	70,156.23	-40,065.43	233.15
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,679,774.90	0	2,679,774.90	0.00
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0	0	0.00	
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0	0	0.00	
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	0	0	0.00	
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	3,031,230.90	1,429,680.06	1,601,550.84	47.17
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	3,031,230.90	1,429,680.06	1,601,550.84	47.17
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	803,169.41	-803,169.41	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	914,280.92	-914,280.92	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	44,558.50	43,063.50	1,495.00	96.64
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	193	193	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	178	178	0.00	100.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	15	15	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5,281.50	5,283.50	-2.00	100.04
620001	Удирдах ажилтан	375	375	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3,175.50	3,167.50	8.00	99.75
620003	Үйлчлэх ажилтан	1,366.00	1,381.00	-15.00	101.10
620004	Гэрээт ажилтан	365	360	5.00	98.63
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	39,071.00	37,574.00	1,497.00	96.17

630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	29,902.00	28,986.00	916.00	96.94
630001	Төрийн өмчит ЕБС	29,699.00	28,783.00	916.00	96.92
630002	Хувийн ЕБС	203	203	0.00	100.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	9,169.00	8,588.00	581.00	93.66
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	8,729.00	8,148.00	581.00	93.34
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага	440	440	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	13	13	0.00	
